



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/230

Өмнөдэлгэр сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 25-3018 дугаартай шинжилгээний хариугаар тус сумын Талын булаг багийн “Дунд сайхан” гэх газарт нутаглаж буй малчин Т.Баярсайханы суурьт Галзуу өвчин оношлогдсон тул, 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалт тогтоосон бүсээс амьд мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхийг хориглосугай.

3. Голомтын суурийн малд үзлэг хийж, хашаа хороог халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахыг Хичээнгүй экспресс мал эмнэлэг (Ц.Ганбат)-т даалгасугай.

4. Тус арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг Гамшгийн эрсдэлийн сангаас зохих журмын дагуу зарцуулж ажиллахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Оюунгэрэл)-д, малчдад зөвлөмж мэдээлэл хүргэж ажиллахыг Багийн Засаг дарга (М.Сод-Ирээдүй)-д, аймгийн Мал эмнэлгийн газарт цагийн байдлыг мэдээлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (С.Гантогоо)-т тус тус үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj